

ОРОН НУТГИЙН СОНИНЫ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ЗАРИМ
СУДАЛГАА

Б.Болормаа*, Д.Дагиймаа**

*Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхим, докторант

**Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхим, профессор

Түлхүүр үгс: Орон нутгийн сонин, сэдэв, агуулга, бичлэгийн төрөл зүйл.

Итали Улсын Мантуа хотод, 1664 онд анхны дугаараа эрхлэн гаргасан “Gazzetta di Mantova”-г анхны Орон нутгийн сонин (Цааш: ОНС) гэдэг. Уг сонин нь орон нутгийн засаг захиргаа болон улс төрийн эрх мэдлээс ангид бие даасан байр суурь бүхий хэмээн өөрсдийгөө тодотгож ирсэн ба өнөөг хүртэл үйл ажиллагаагаа тогтвортой явуулсаар байна. 1700-1800 онд Британи, Британийн эзэнт гүрний колони орнуудын муж тосгонд ОНС хэвлэгдэн гарчээ. Япон, Солонгос зэрэг Азийн орнуудад 1800 оны сүүлээс 1900 оны эхэн хүртэл ОНС-ууд хэвлэгдэн гарсан байна.

Монгол Улсад 1942 онд Баян-Өлгий аймагт “Өркендеу” буюу “Дэвшил” нэртэйгээр казах хэлээр сонин хэвлэгдэн гарснаар анхны ОНС бий болов. Үүний дараа 1944 оноос Ховд, Өвөрхангай аймагт Монгол хэлээр ОНС хэвлэгдэн, 1944 оны 5 сард намын ТХ-ны “Тус оронд хэвлэгдэж буй тогтмол хэвлэлийн чанарыг сайжруулах тухай” тогтоолын дагуу ОНС-ы эрхлэгчдийн зөвлөгөөнийг байнга хийлгэж, нийтлэх зүй-

лийн талаар чиглэл өгч, сонин гаргахтай холбогдсон материал, техникээр хангах үүргийг холбогдох газруудад өгөх болжээ (Дэлэг.Г, Монголын хэвлэл 1940-1970, 1971). Үүнээс хойш 1950 он гэхэд үндсэндээ аймаг бүр ОНС-той болж, 1970-аад оны дунд үед, бүх аймгийн сонины газар өөрийн бүтцэд 15-25 техникийн мэргэжилтэн-тэй хэвлэх үйлдвэртэй, мэргэжлийн сэтгүүлч бүхий редакцтай ОНС-ы систем тогтон бэхэжсэн байна.

Гэвч, ардчилал шилжилтийн үе буюу 1990 оноос хойш өмнө нь төвийн сонинуудын агуулгыг давтдаг байсан ч, хүчээр захиалуулж ирсэн ОНС-ыг сайн дураараа захиалах хүнгүй болж аргагүйн эрхэнд олонх сонин хэвлэлтээ зогсоосон (Норовсүрэн, 2001). 1998 онд Хууль зүйн дотоод хэргийн яаманд бүртгэлтэй ОНС-ы тоо 10 хүрэхгүй байсан нь шилжилтийн үеийн хүнд нөхцөлийг илтгэх юм. Энэ талаар профессор М.Зулькафиль “цаашид аймагт гарч байгаа хэд хэдэн сонин нэгтгэж, хэмжээг томсгож, гаралтыг, цөөрүүлэх замаар чанарыг дээшлүүлэх арга замыг эрж хайх нь чухал” хэмээн тэмдэглэсэн байна (Зулькафиль.М, 1994). Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 24 ОНС

үйл ажиллагаа явуулж буй ба орон нутгийн таван хэвлэл мэдээллийн хэрэгсэл тутмын нэг нь ОНС байгаагаас, орон нутгийн иргэдийг мэдээ мэдээллээр хангах хүчирхэг мэдээллийн хэрэгсэл байсаар байна.

Тус судалгаанд 1970-1980 он буюу ОНС-ы систем бэхжин төлөвшсөн үе болон өнөөдрийн 2022 оны ОНС-ы мэдээ мэдээллийн агуулга, бичлэгийн төрөл зүйлд харьцуулсан шинжилгээ хийн өнөөгийн байдал, тулгарч буй асуудлыг дүгнэх болно.

Нэг. Социалист системийн үеийн орон нутгийн сонинд хийсэн шинжилгээ: 1976 онд Эрдэнэт хотод “Эрдэнэт” сонин хэвлэгдсэнээр, манай

улсын бүх аймгууд өөрийн сонинтой болсон бөгөөд нийт 20 ОНС гарч байв (Одоо-гийн Говьсүмбэр аймгаас бусад бүх аймаг). 1980-аад оны эхээр 5–13 мянган хувиар 7 хоногт 2 удаа, жилд 104-108 дугаар хэвлэгдэж байв. Хамгийн олон захиалагчтай нь Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонин 13–14 мянган хувиар, хамгийн цөөн нь Өмнөговь аймгийн “Говийн мэдээ” сонин 3-5 мянган хувиар хэвлэгдэж байжээ. Энэхүү ОНС-ы төлөвшлийн үеийн Архангай, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь аймгийн сонинуудын мэдээллийн агуулга, боловсруулалт зэргийг судаллаа.

Аймгийн нэр	Архангай	Өмнөговь	Дорнод	Сэлэнгэ	Дорноговь
Сонины нэр	"Архангайн үнэн"	"Говийн мэдээ"	"Дол"	"Сүхбаатарын туг"	"Ялалт"
Үүсгэн байгуулагдсан он	1947	1945	1945	1948	1945
Судалгаа хийсэн дугаарууд	1969-09-01. №67-аас 1970-06-25.№50 хүртэл	1969-06-16 №45-аас 1969-12-29.№96 хүртэл	1970-07-25 №59-аас 1970-12-23.№96 хүртэл	1971-03-22. №22-аас 1971-06-07.№43. хүртэл	1975-05-31. №41- аас 1975-10-11.№76 хүртэл
Долоо хоногийн гаралт	2 (Даваа, Пүрэв)	2 (Даваа, Пүрэв)	2 (Лхагва, Бямба)	2 (Даваа, Пүрэв)	2 (Лхагва, Бямба)
Хуудасны тоо	4	4	4	4	4
Уриа	Орон бүхний пролетари нар нэгдэгтүн	Орон бүхний пролетари нар нэгдэгтүн	Орон бүхний пролетари нар нэгдэгтүн	Орон бүхний пролетари нар нэгдэгтүн	Орон бүхний пролетари нар нэгдэгтүн
Харьяалал	Архангай аймгийн Намын хороо, Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны сонин	Өмнөговь аймгийн Намын хороо, А.Д.Х гүйцэтгэх захиргааны сонин	Дорнод аймгийн Намын хороо, А.Д.Х гүйцэтгэх захиргааны сонин	Сэлэнгэ аймгийн Намын хороо, А.Д.Х гүйцэтгэх захиргааны сонин	Дорноговь аймгийн Намын хороо, А.Д.Х гүйцэтгэх захиргааны сонин
Хэвлэсэн газар	"Архангайн үнэн" сонины СХ-ийн хэвлэх үйлдвэр	"Говийн мэдээ" сонины Социалист Хөдөлмөрийн үйлдвэр	Дорнод аймгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв	Сүхбаатарын туг сонины үйлдвэрт хэвлэв	Ялалт сонины үйлдвэрт хэвлэв

Хүснэгт №.1. Орон нутгийн сонины үндсэн нүүрэнд хийсэн судалгаа


Таван ОНС-ы долоо хоногийн гарал-тын давтамж бүгд ялгаагүй 2 байх ба нүүрний тоо болон уриа, харьяалал нэг жигд адилхан байна. Мөн сонины сүүл хэсгээс бүгд тус тусын аймагтаа хэвлэгдэн гарч

байсан ба хариуцлагатай эрхлэгчийн нэрийг байршуулсан байна.

1.1. Мэдээ мэдээллийн сэдэв: ОНС-ы мэдээ мэдээллийн сэдэв бол нэн тэргүүнд тавигдах чухал ойлголт юм. Нийгмийн амьдралд тулгамдсан

асуудал эсвэл тэдгээрийн учир шалтгааныг нь тунгаан асуудлыг шийдэх арга, байр суурь, үзэл бодлоо тухайн сэдвээр дамжуулан илэрхийлэгддэг билээ (Нямсүрэн, 1984). Таван сонины

мэдээллийн сэдвийн хувьд (Зураг №.1) хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэр, хөдөөгийн амьдралын тухай мэдээлэл нь дугаар бүрийн ашигтай талбайн 50-60 хувийг эзэлж байна.



Зураг №.1. 1970 -1975 оны сонины мэдээллийн сэдэв.

Жишээ нь, 1970 оны 6 сарын 22-ны өдрийн "Архангайн үнэн" сонины 1-р нүүрний 50 хувьд "Малд тарга хүч авхуулахад бүхнийг дайчилъя", 2-р нүүр болон 3-р нүүрт "Аймгийн тэргүүний үхэрчдийн зөвлөгөөнд оролцогчдоос нийт үхэрчдэд хандаж гаргасан зөвлөмж" гэх мэт мэдээлэл нь нийт мэдээллийн 70 гаруй хувийг эзэлж байна. 1969 оны 6 сарын 16-ны өдрийн Даваа гаригийн "Говийн мэдээ" сонины 1-р нүүрний 30 хувьд "Их ойд эрчимтэй бэлтгэе", 1-р нүүрт "Аймгийн 1969 оны аж ахуйн зарим төлөвлөгөөт ажлын биелэлт", 4-р нүүрний 40 хувьд "Их ой угтаж зохиох ажлаа эрчимжүүлье" гэх нийтлэл гарчээ. 1975 оны 11 сарын 20-ны өдрийн "Ялалт" сонины 1-р нүүрний 60 хувьд "Улсын тэргүүний тэмээчдийн анхдугаар зөвлөлгөөн", 2, 3, 4-р нүүр бүтэн "Аймгийн намын хорооны IV бүгд хурлын тогтоол: Суурь дахь өвлийн

бэлтгэлийн байдал, мал өвөлжүүлэх хаваржуулах арга хэмжээний тухай" нийтлэгдсэн нь үндсэндээ сонины нийт ашигтай талбайн 80 хувь нь хөдөө аж ахуй, газар тариалан, хөдөөгийн амьдралын тухай юм. 1975 оны 12 сарын 1-ний өдрийн "Ялалт" сонины 2-р нүүрний 30 хувьд "Хөдөө аж ахуйн мэргэжилтний аттестатчилал", 3-р нүүрний 30 хувьд "Адууны отрыг даруй гаргая" гэх мэдээлэл байна. Мөн сонины мэдээллийн 5-20 хувийг төр, олон нийтийн байгууллага, 20-35 хувийг уран сайхан соёл урлагийн мэдээ эзэлжээ.

Сонины нийтлэл бүрийн доор хэний бүтээл болох нь тодорхой харагдах овог нэр байна. Нэрийн араас хаалтад "манай идэвхтэн бичигч" эсгэвэл "манай идэвхтэн", "манай сурвалжлагч", "сурагч" гэх мэт бичсэн байх ба тухайн үеийн ОНС-ы нэг онцлог нь өөрийн аймаг, хотын мэдээллийг олж

нийтлэх гол эх сурвалж, тулгуурлах хүч нь идэвхтэн бичигчид байв. Тэд аймаг сумын намын хороо, захиргааны газар, томоохон үйлдвэр, албан газарт ажиллаж, дунджаар нэг аймаг 60-100 гаруй идэвхтэн бичигчидтэй байв. Нэг дугаарын мэдээллийн 50 хувиас доошгүйг бичиж нийлүүлдэг, редакцаас үнэмлэх олгож, заавар зөвлөгөө өгч, мэргэжлийн тусламж үзүүлдэг байжээ.

1.2. Бичлэгийн төрөл зүйл:

Дээрх 5 сониныг бичлэгийн төрөл зүйлийн хэлбэрээр нь ангилан судаллаа (Зураг №.2). Бичлэгийн төрөл зүйл нь франц хэлний genre (жанр) гэсэн үгнээс гаралтай төрөл зүйл гэсэн утгатай үг. Жанр буюу бичлэгийн төрөл зүйл хэмээх ойлголтыг дэлхийн төдийгүй Монголын сэтгүүл зүйн тулгуур бүтээлүүдэд янз янзаар тодорхойлсон байдаг. Жишээ нь, профессор Ж.Батбаатар сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийг мэдээллийн, хөрөглөл бичвэрийн, шинжлэлт бичвэрийн төрөл гэж 3 хуваан үзэх боломжтой (Батбаатар.Ж, 2010). Профессор М.Зулькафиль нь “Манай сэтгүүл зүйд тогтмол хэвлэлийн материалуудыг бичлэгийн гол төлөв төрөл зүйлийн шинж тэмдгээр ялгаж мэдээллийн, задлан шинжилсэн, нийтлэл-уран сайхны гэсэн гурван том хэсэгт хуваадаг” хэмээн тодорхойлжээ (Зулькафиль.М, 1994). Мөн бичмэл хэвлэл мэдээллийг дэлхийн эрдэмтэд сүүлийн үед мэдээллийн (informative), үзэл бодлын (opinion), тайлбарлах (interpretive) төрлөөр түлхүү ангилах болжээ (Mushtaq, 2021). Мөн Сато нь “Бичлэгийн төрөл зүйл бол цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагыг даган өөрчлөгдсөөр ирсэн” ба интернэт техник технологийн хөгжилтэй зэрэгцээд “туслах бичлэгийн төрлүүд” ихээхэн хөгжиж байгааг тодотгосон байдаг (Сато, 2017). Энэ талаар профессор


М.Зулькафиль нь “Бичлэгийн төрөл зүйл бол цаг үеэ даган өөрчлөгдөж байдаг бөгөөд энэ нь одоог хүртэл нэг мөр болж шийдэгдээгүй маргаантай асуудал юм. Бичлэгийн төрлийн шинж чанар нь цаг үеийн шаардлага, уншигчдын эрэлт хэрэгцээг дагаж тодорхой хэмжээнд өөрчлөгддөг жамтай юм” гэжээ (Зулькафиль.М, 1994). Эдгээр сэтгүүл зүйн тулгуур бүтээлүүдийн үндсэн зарчмуудыг баримтлан, бид үндсэн дөрвөн төрлөөр задлан судаллаа.

Мэдээллийн бичлэгийн төрлүүд нь болж буй үйл явдал, үзэгдэл баримтын талаар шуурхай мэдээлэл өгөх зорилготой. Үүнд мэдээ, ярилцлага, сурвалжилга (сурвалжилсан тэмдэглэл, аян замын тэмдэглэл), тайлан мэдээ багтана. Задлан шинжилсэн буюу шинжлэлт бичлэгийн төрлүүд нь сонгож авсан үйл явдал, үзэгдлийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар асуудлын шалтгаан, үр дагавар, ач холбогдлыг гаргаж, үнэлэлт дүгнэлт өгөхийг чухалчилдаг. Үүнд өгүүлэл, тойм, шүүмж, сурвалжилсан тэмдэглэл орно. Нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүдийн онцлог нь үйл явдлыг уран сайхны аргаар дүрслэн үзүүлэх зорилго тавьдаг. Энд найруулал, зураглал, шог найруулал, улс төрийн шог, уран сайхны шүүмжлэл, уран нийтлэл зэрэг багтдаг. Туслах бичлэгийн төрлүүд нь хүлээн авагчдад нэмэлт мэдээлэл өгөх зорилготой бөгөөд энд танин мэдэхүй, захидал, анкет, ном зүй, эмгэнэл, намтар, зөвлөмж, залруулга зэрэг зүйлүүдийг хамрууллаа.

Сонгож авсан 5 сонины нийт бичлэгийн төрлийн харьцааг харвал, мэдээллийн бичлэгийн төрөл дунджаар 65 хувийг эзэлж байна. Жишээ нь, 1970 оны 6 сарын 25-ны өдрийн “Архангайн Үнэн” сонины дугаарт “Монгол хувьс-

галчдын өдөр”, “хувьсгалчдын өдрөө тэмдэглэж байна”, “Хувьсгалчдын өдрөө угтсан амжилт” мэдээ сурвалжилгууд, “Хувьсгалын цэрэг, Хувьсгалын Өлгий нутагт бичсэн тэмдэглэл” аян замын тэмдэглэл, “Эрх чөлөөний их үйлчин” сурвалжилсан тэмдэглэл зэрэг нь сонины нийт ашигтай талбайн 80 гаруй хувийг эзэлжээ. 1970 оны 12 сарын 9-ний өдрийн “Дөл” сонины 1-р нүүрний 80 хувийг “Намын анхан шатны байгууллага”, “Сум дундын эмнэлэг”

мэдээ, 2-р нүүр бүтэн “Аймгийн намынхорооны VI бүгд хурлын тогтоол”-ийн талаар сурвалжилсан мэдээ, 3-р нүүр-ний 95 хувийг “Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулъя”, “Тайландаа бэлтгэж байна зэрэг” мэдээ 4-р нүүрний 80 хувийг “Аймгийн ҮЭ-ийн идэвхтний зөвлөгөөнөөс гаргасан уриалга”, “Хөдөлмөр хүмүүжлийн сургууль” тайлан мэдээ зэрэг нь сонины нийт ашигтай талбайн 75 гаруй хувийг эзэлжээ.



Зураг №.2. Орон нутгийн сонины бичлэгийн төрөл (хувиар).

Нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөл 10 хүртэлх хувийг эзлэн, яруу найраг, номын тэмдэглэл, өгүүллэг зэрэг тогтмол нийтлэгдэж байв. Жишээ нь, 1975 оны 10 сарын 30-ны өдрийн “Ялалт” сонины 2-р нүүрт “Монгол, Зөвлөлтийн найрамдлын сард: Найрамдлын хэл, говь нутагт” найруулал, 4-р нүүрт Т.Галсаншаравын “Суварга хайрхан” яруу найраг байна. 1971 оны 3 сарын 24-ний өдрийн “Сүхбаатарын туг” сонины 2-р нүүрт “Ардын хувьсгалын 50 жил, ахмад дайчны яриа” найруулал, 3-р нүүрт “Хөдөө нутгийн сайхан. Малчны халаа, залуус” нийтлэл, мөн 3-р нүүрт “Малчин ардаа магтнам” шүлэг зэрэг нийтлэгдсэн байна.

Харин шинжлэлт бичлэгийн төрөл ховор. Жишээ нь, 1975 оны 10 сарын 30-ны өдрийн “Ялалт” сонины 3-р нүүрт “Сумын мал аж ахуйн ерөнхий тойм”, “Манай нэгдэл 20 жилд” зэрэг богино тоймууд байна. Мөн захидал болон зөвлөгөө, “Таны сонирхолд” зэрэг танин мэдэхүйн чанартай туслах бичлэгийн төрлүүд цөөнгүй байна. 1971 оны 11 сарын 25-ны өдрийн “Сүхбаатарын туг” сонины 4-р нүүрт “Хөдөлмөрчдийн захидал: Шуудангийн үйлчилгээг шуурхай болгоё”, “Мэргэжилтний зөвлөмж: Арьс ширийг хэрхэн бэлтгэх вэ”, өмнөх дугаарын залруулга болон зарлал зэрэг орсон байна. 1970 оны 11 сарын 4-ний өдрийн “Дөл” сонины 4-р нүүрний 30 хувийг “Эмчийн зөвлөлгөө: Түлэгдэгс-

дэд үзүүлэх тусламж”, 1975 оны 12 сарын 1-ний өдрийн “Ялалт” сонины 4-р нүүрт “Эмч зөвлөж байна: Элэгний халдварт шар өвчний архагшдагийн учир”, “Жамьянгийн Цэсэндoo” эмгэнэл, зарлал зэрэг орсон байна. Туслах бичлэгийн төрлүүд гол төлөв сонины дөрөвдүгээр нүүрт хэвлэгдэж байжээ. Ийнхүү бичлэгийн олон төрлөөс ОНС нь онцлох чухал сэдэв үйл явдлын мэдээллийг олон хэлбэрээр хүргэж, орон нутгийн бүх иргэдийн сонирхол татахуйц хэвлэл мэдээлэл байжээ гэж хэлж болох юм.

Ө НӨӨГИЙН ОРОН НУТГИЙН СОНИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ: 2021 оны байдлаар нийт 24 ОНС байна.

Тус хэсэгт зургаан аймгийн ОНС-ыг сонгон авч орон нутгийн асуудлыг ямар түвшинд тусгаж байна, ямар сэдвээр түлхүү нийтэлдэг эсэх талаар тогтоохыг зорилоо. Орон нутгийн 6 сониныг сонгохдоо 7 хоног тутмын 2, 10-14 хоног 7 хоног тутмын 2, сар тутмын 2 сониныг сонгон авлаа.

Аймгийн нэр	Сонины тоо	Аймгийн нэр	Сонины тоо	Аймгийн нэр	Сонины тоо
Архангай	2	Дорноговь	1	Сүхбаатар	1
Баян-Өлгий	1	Дорнод	2	Сэлэнгэ	1
Баянхонгор	1	Дундговь	1	Төв	0
Булган	1	Завхан	1	Увс	1
Говь-алтай	1	Орхон	2	Ховд	2
Говьсүмбэр	0	Өвөрхангай	0	Хөвсгөл	1
Дархан-Уул	0	Өмнөговь	2	Хэнтий	1

Хүснэгт №. 2. Орон нутгийн сонины тоо аймгуудаар.

1990 оноос өмнөх сонинууд нэг ижил уриатай байсан бол эдгээр зургаан ОНС-ы толгойд байрлах уриа бүгд өөр. Зарим сонин уриагүй ба дугаар бүрийн уриа өөр байна (Хүснэгт №.3). Жишээ нь, “Сэлэнгийн мэдээ” сонины хувьд, 2021 оны 9 сарын сонин “Хийморь өөдөө Сэлэнгэчүүддээ”, 2022 оны 4 сарын сонин “Зовхи нь өөдөө Сэлэнгэчүүддээ” гэх мэт уриагаа сольж

байгаа ба Дундговь аймгийн “Дундговийн амьдрал” сонин уриагүй. Харин 2019 оны 1 сарын 21-ний өдрийн “Дундговийн амьдрал” сонин нь “Манай сонины 2019 оны захиалга үргэлжилж байна”, 2019 оны 5 сарын 22-ны өдрийн сонин нь “Та Dundgovi.mn вебсайтаас зар мэдээллээ тогтмол хүлээн авна уу” гэсэн сурталчилгааг нүүрний дээд хэсэгт байрлуулжээ.

Аймгийн нэр	Өмнөговь	Сэлэнгэ	Сүхбаатар	Булган	Завхан	Дундговь
Сонины нэр	"Говийн мэдээ"	"Сэлэнгийн мэдээ"	"Сүхбаатарын Өнгө"	"Булганы мэдээ"	"Завхан"	"Дундговийн амьдрал"
Үүсгэн байгуулагдсан он	1945	2002	2014	2003	2005	2013
Нэг дугаарын үнэ	1000	2500	800	1000	800	1000
Нийт борлуулалт (2020)	6000	-	18000	24000	43200	48000
Нэг сард гардаг дугаарын тоо	1	1	3	2	4	4
Хуудасны тоо	12	4	4	4	4	4
Уриа	Өмнөговь аймгийн анхны сонин	... өөдөө сэлэнгэчүүддээ	Нутагтаа сайхан амьдаръя	Төрөлх Булган нутгаа хөгжүүлэе	Байгаль орчны хөгжилд хамтдаа	байхгүй
Харьяалал	"Говийн мэдээллийн хөтөч" ХХК	"Эгэл" ХХК	"Сүхбаатарын өнгө сонин" ХХК	"Булганы мэдээ сонин" ХХК	"Эгэл" ХХК	"Эгэл" ХХК
Хэвлэсэн газар	"Чөлөөт хэвлэл сан"	"Чөлөөт хэвлэл сан"	"Чөлөөт хэвлэл сан"	"Чөлөөт хэвлэл сан"	"Чөлөөт хэвлэл сан"	"Чөлөөт хэвлэл сан"


Хүснэгт №.3. Сонины үндсэн нүүрэнд хийсэн судалгаа.

Социалист системийн үеийн ОНС-ууд бүгд адил 4 нүүрээр гардаг байсан бол, 1990 оноос хойших ОНС-ууд 4-12 нүүрээр гарч байна. Сардаа нэг дугаар гаргадаг Өмнөговь аймгийн "Говийн мэдээ" сонин нь 12 нүүрээр гардаг нь хамгийн олон нүүртэй сонин юм. Мөн 1990 оноос өмнөх сонинууд бүгд тус тусын аймагтаа хэвлэгдэн гарч байсан бол эдгээр зургаан аймгийн төдийгүй бүх аймгийн ОНС-ы эх нь аймгийн редакадаа бэлтгэгдэн, дараа нь Улаанбаатарт байрлах "Чөлөөт хэвлэл сан"-д хэвлэгдэж байна. Мөн сэтгүүлчийн нэр сонинд бичигдээгүй байгаагаас харахад, сонины эрхлэгч нь ганцаараа эсвэл мэргэжлийн сэтгүүлч нь байнга солигдож, хүн хүч дутмаг байдлыг илтгэж байна. "Сэлэнгийн мэдээ" сонин нь менежерийн нэрийг утасны дугаарын хамт тодотгон байрлуулжээ. Энэ нь зар реклам сурталчилгааг байрлуулах боломжийг илтгэн, нөгөөтэйгөөр сонины

санхүүгийн эх үүсвэр нь борлуулалт, үйлчилгээ, мэдээлэл сурталчилгааны орлого болсон гэдгийг харуулах юм. Өөрөөр хэлбэл, социалист системийн үед ОНС-ы хэвлэл, редакц, мэргэжлийн сэтгүүлч бүхий систем тогтон бэхэжсэн байсан бол, 1990 оноос хойших ОНС-ууд өөрийн гэсэн хэвлэх үйлдвэргүй, мэргэжлийн сэтгүүлч бүхий тогтвор суурьшилтай редакцгүй болсон байна.

2.1. Мэдээ мэдээллийн сэдэв:

Эдгээр сонины мэдээллийн сэдвийг ангилан хуваалаа (Зураг №.3). Зургаан сонины мэдээллийн сэдвийг харвал хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэр, орон нутгийн амьдралын тухай мэдээлэл нь дугаар бүрийн 15-35 хувийг эзэлжээ. Төр, олон нийтийн байгууллагын ажлын мэдээ мэдээлэл 40-65 хувийг, өгүүлэл, уран сайхны болон яруу найраг, номын талаар болон соёл урлагийн мэдээлэл 5-20 хувийг эзэлж байна.



Зураг №.3. 2022 оны сонины мэдээллийн сэдэв.

ОНС-ы ашигтай талбайн 40-65 хувь буюу ихэнх нь төрийн байгууллагын мэдээ, хууль дүрэм журам, захиалгат, гэрээт реклам сурталчилгаа гэх мэт сэтгүүл зүйн бус мэдээллүүд байна. Сонинууд Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Баг, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлаас болон хувийн аж ахуй нэгжээс гэрээгээр мэдээлэл авах төдийгүй орлогын эх үүсвэр болсон реклам зар сурталчилгааг түлхүү нийтлэн оруулж байна. Жишээ нь, 2022 оны 4 сарын “Сэлэнгийн мэдээ” сонин нь “Сүхбаатар сумын ИТХ-ын ажлын албанаас мэдээлж байна”, “Татварын хэлтсийн дарга Ц.Лхагвадоржийн мэндчилгээ”, “ХЦ-ийн 0101-р анги”, “Аймгийн ЭМГ”, “Аймгийн Онцгой Байдлын Газар”, “Аймгийн Цагдаагийн газар”, “УИХ-ын гишүүн Ч.Ундрамын ажлын албанаас мэдээллээ” гэх мэт мэдээнүүд сонины ихэнх хувийг эзэлж байна. 2019 оны 5 сарын 22-ны өдрийн “Дундговийн амьдрал” сонин нь “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам” сони-


ны 2-р нүүрэнд бүтэн, мөн 2019 оны 1 сарын 21-ний өдрийн дугаарт аймгийн хэмжээний нийт “Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц” 2-р нүүрийн 90 хувьд нийтлэгдсэн байна. “Булганы Мэдээ” сонин мөн 2-р нүүрийг төрийн байгууллагын мэндчилгээ болон мэдээллээр дүүргэсэн байна. Тус сонины 2021 оны 10 сарын 11-ний өдрийн 2-р нүүрэнд Булган аймгийн “Стандарт хэмжил зүйн хэлтэс байгуулагдсаны 40 жилийн ойн мэндчилгээ”, 2021 оны 12 сарын 10-ны өдрийн дугаар 2-р нүүрэнд Булган аймгийн Жендерийн салбар хорооны мэдээлэл “Жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх хандлага” нүүр дүүрэн хэвлэгджээ. 2022 оны 4 сарын 25-ны өдрийн “Сүхбаатарын өнгө” сонин нь “Онцгой байдлын газраас мэдээлж байна”, “Эрүүл мэндийн газраас мэдээлж байна”, “Дарьгангын байгалийн цогцолборт газрын захиргаа” “МСҮТ-өөс мэдээлж байна” гэх мэдээллүүд ашигтай талбайн 65 хүртэлх хувийг эзэлсэн байна.

Төр, олон нийтийн байгууллага, намын ажлын мэдээ мэдээлэл элбэг байгаа нь мэргэжлийн сэтгүүлч дутмаг

байгаагийн нэг илрэл гэж хэлж болох юм. Иймд орон нутгийн сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээ мэдээлэл ОНС-д хэр их ноогдож байгааг тооцооллоо. Зургаан ОНС-ы ашигтай талбайн 37-45 хувь нь л орон нутгийн сэтгүүлчдийн өөрсдийн бэлтгэсэн сэтгүүл зүйн бүтээл бүхий мэдээллүүд байна. “Говийн мэдээ” сонин 3-р нүүр цаг үеийн мэдээ, 4-5-р нүүр нь тогтмол “Ярилцъя”, 9-р нүүр “Байгаль Экологи” болон “Уул Уурхай”, 10-р нүүр “Танин мэдэхүй” гэх мэт өөрсдийн сэтгүүлчдийн бэлтгэдэг булан байгаа нь бусад ОНС-оос ялгарч байна. “Сэлэнгийн мэдээ” сонин 2-р нүүрэнд “Сэлэнгэ тойм” булангаар өөрсдийн бэлтгэсэн мэдээ мэдээллийг хүргэж байгаа боловч, энэ булан нь тогтмол бус. “Сүхбаатарын өнгө” сонин 1-р нүүрний 40 хувьд мэдээ мэдээлэл, 3

нүүрэнд ярилцлага, түүх гэх мэт оруулахаас өөр өөрийн сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээлэл байхгүй нь харагдана. “Булганы Мэдээ” сонин өөрсдийн бэлтгэсэн цаг үеийн мэдээг “Айраг сөгнөх мөчид” булангаар 1-р нүүрний 40–50 хувьд нь тогтмол хэвлэж байна. “Дундговийн амьдрал” сонин “Редакцын 20 мөр”, “Орон нутгаас” буланд өөрсдийн сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээг оруулжээ.

2.2. Бичлэгийн төрөл зүйл: Зургаан сонин бичлэгийн дийлэнх хувийг мэдээ, ярилцлага эзэлж байна. Ярилцлага оруулаагүй дугаар байхгүй ба, ярилцлага нь бичлэгийн голлох төрөл болжээ. Жишээ нь, “Говийн мэдээ” сонин 4-5 нүүр “Ярилцъя” буланг, “Сүхбаатарын өнгө” сонин 3 нүүрэнд ярилцлага тогтмол орж байна.



Зураг №.4. Орон нутгийн сонин бичлэгийн төрөл (хувиар).

Танин мэдэхүйн булан болон зар сурталчилгааны гэх мэт туслах бичлэгийн төрлүүд тогтмол нийтлэгдэж байна. Жишээ нь 2021 оны 12 сарын 17-ны өдрийн “Завхан” сонин 4-р нүүрний 80 хувийг “Нээлттэй дуудлага худалдааны зар”, “Ажилд авна”, “Хүчингүйд тооцов” зэрэг зар сурталчилгааны мэдээллүүд байна. “Завхан” сонин 4-р нүүрний талаас илүү хувь нь тогтмол зар сурталчилгааны мэдээлэл орсон байна. Мөн 2021 оны 10 сарын 11-ний

өдрийн “Булганы Мэдээ” сонин 4-р нүүрт, “Мэдэхэд илүүдэхгүй” булан “Гангын гайхалтай ач тус”, “Хүнсний содыг эмчилгээний зориулалтаар ашиглах 18 арга” зөвлөгөө, “Нээлттэй дуудлага худалдааны зар” зэрэг нийтлэгдсэн байна. Нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлийн хувьд, “Сүхбаатарын өнгө” сонин нь тогтмол шүлэг яруу найраг нийтлэн энэ төрлийн бичлэгийн төрлөөр баялаг байна. Жишээ нь, 2022 оны 3 сарын 21-ний өдрийн “Сүхбаа-

тарын өнгө” сонины 4-р нүүрт “Аавдаа” шүлэг, “Завь” сургамжит өгүүллэг, 3-р нүүрт “Хүйтэн цармын хүн цэцэг Вансэмбэрүү” найруулал зэрэг орсон байна. 2022 оны 4 сарын 4-ний өдрийн сонины 4-р нүүрт “Утга зохиол булан”-д Лутбаярын Батбаярын шүлэг “Ээждээ”, “Монгол Бүсгүй”, “Талын Агуй” шүлгүүд байна. Мөн 2021 оны 10 сарын 11-ний өдрийн “Булганы Мэдээ” сонины 3-р нүүрний 50 хувьд Цэрэндоржийн Лхагвасүрэнгийн “Могод нутгийн магтаал” шүлэг орсон байна. Бусад сонинд өгүүллэг, яруу найраг, номын тэмдэглэл, найруулал гэх мэт нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүд нийтлэгдээгүй байна. 1990 оноос өмнөх ОНС-ы бичлэгийн төрөл нь нэгэн жигд байсантай харьцуулан үзвэл хүн амын бүх давхаргыг хамарсан захиалагч уншигчдынхаа хувьд нийтлэг хэвлэл мэдээлэл байсан онцлог нь алдагдсан байна. Эдгээрээс ОНС нь онцлох сэдэв үйл явдлын мэдээллийг олон хэлбэрээр хүргэж чадахгүй, иргэдийн сонирхол татахуйц мэдээллийн хэлбэртэй бус байна гэж үзэж болох юм.

Дүгнэлт: 1990 оноос өмнөх ОНС-ууд мэргэжлийн сэтгүүлч бүхий редакцтай, өөрийн бүтцэд хэвлэх үйлдвэр бүхий системтэй байсан бол, 1990 оноос хойших ОНС-ууд мэргэжлийн сэтгүүлч бүхий тогтвор суурьшилтай редакцгүй болов. 1990 оноос өмнөх ОНС-д хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэр, хөдөөгийн амьдралын тухай мэдээлэл нь дугаар бүрийн 50-65 хувийг, 20-30 хувийг төр, олон нийтийн байгууллага, намын ажлын мэдээ мэдээлэл, уран сайхан соёл урлагийн бусад нийтлэл мэдээ 15-20 хувийг эзэлжээ. Гэвч өнөөдөр ОНС-ы ашигтай талбайн 45-70 хувь буюу ихэнх нь төрийн байгууллагын мэдээ, хууль дүрэм журам, захиалгат, гэрээт реклам

сурталчилгаа гэх мэт сэтгүүл зүйн бус мэдээллүүд болжээ.

Мөн бичлэгийн төрөл зүйлийн хувьд, 1990 оноос өмнөх сонинтой харьцуулахад ярилцлагын тоо эрс нэмэгдэн, ярилцлага нь бичлэгийн төрөлд гол байр эзлэх болжээ. 1990 оноос хойших “чөлөөт хэвлэл” либертари сэтгүүл зүйн зарчмын дагуу, орон нутгийн сонинд нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүд эрс багассан байна. Харин танин мэдэхүйн булан болон зар сурталчилгааны гэх мэт туслах бичлэгийн төрлүүд тогтмол нийтлэгдэж байна.

ОНС төдийгүй орон нутгийн хэвлэл мэдээллийн нэг онцлог нь үзэгч уншигчдынхаа хувьд хүн амын бүх давхаргыг хамардаг. Энэхүү онцлог нь сонины мэдээ мэдээллийн чиглэлд нөлөө үзүүлдэг байх хэрэгтэй. Жишээ нь, аймгийн Тамгын газрын бодлого, мэдээ мэдээллийг хүн амын бүх давхаргад хүргэх хүртээмжтэй арга нь хэн ч нэвтрүүлсэн мэдээнээс заавал нэг зүйлийг мэдэж авахуйц, бичлэгийн олон төрөл зүйлээр бичигдсэн байх юм. Гэвч өнөөгийн ОНС нь онцлох сэдэв үйл явдлын мэдээллийг олон хэлбэрээр хүргэж чадахгүй, орон нутгийн иргэдийн сонирхол татахуйц мэдээллийн хэлбэртэй бус байна. Цаашид, тодорхой хугацаанд хүн амын давхаргын онцлогт тохирсон нүүр буланг тогтмол гарган, тусгайлсан булангийн мэдээ нь малчин, оюутан, сурагч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсдын сонирхол татахуйцаар байхын хамт, тэд өөрсдөө зориулсан дугаар, нүүр буланг шүүрэн авч түүж уншдаг, дараа гарах тогтоосон хугацааг хүлээдэг байх гэсэн хоёр талтай зорилтыг хангах нь чухал юм.

Цаашид тус судалгааг илүү сайжруулахын тулд ОНС-ы дизайн, сэтгүүлчийн

ур чадварын асуудал зэрэгт дэлгэрүүлэн, гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй.

Эшлэл

1. Дэлэг, Г. (1971). *Монголын хэвлэл 1940-1970*. Улаанбаатар. p.84.
2. Норовсүрэн, Л. (2001). *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм*. Улаанбаатар. p.98.
3. Зулькафиль, М. (1994). *Өөрчлөлт шинэчлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл*. Улаанбаатар.p.15-16.
4. Батбаатар, Ж. (2010). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар. p.38-103.
5. Mushtaq, M. (2021). A further grouping: reclassifying the editorial sort. *Journal of applied linguistics and tesol*, 4(3), 25-42.
6. Сато, J. (2017). The genre-specific hypothesis of reading: Reading poetry and encyclopedic items. *Poetics*, 26(2), 63-80.
7. Нямсүрэн, Д. (1984). *Сэтгүүлчийн Ур Чадвар*, Улаанбаатар. p.84.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батбаатар, Ж. (2010). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар.
2. Дэлэг, Г. (1971). *Монголын хэвлэл 1940-1970*, Улаанбаатар.
3. Зулькафиль, М. (1994). *Өөрчлөлт шинэчлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл*, Улаанбаатар.
4. Норовсүрэн, Л. (2001). *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть*. Улаанбаатар.
5. Нямсүрэн, Д. (1984). *Сэтгүүлчийн Ур Чадвар*. Улаанбаатар.
6. Хэвлэлийн хүрээлэн, (2022). *Монголын*

хэвлэл мэдээлэл - Өнөөдөр, Улаанбаатар.

7. Шаравдорж, С. (2007). *Орон нутгийн хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд*. Монгол Улсын Их Сургууль, (магистрын бүтээл). Улаанбаатар.
8. Liverpool Echo., (11 July 2011). *5 The top oldest newspapers*. URL:<https://www.highbeam.com/Registration/Registration1>. хандсан огноо: 07 сарын 21, 2022.
9. Mushtaq, M. (2021). A further grouping: reclassifying the editorial sort. *Journal of applied linguistics and tesol*, 4(3), 25-42.
10. Сато, J. (2017). The genre-specific hypothesis of reading: Reading poetry and encyclopedic items. *Poetics*, 26(2), 63-80.

Summary

In this study, the current situation and problems will be evaluated by comparing the content and types of genre in local newspapers in 1970, when the local newspaper system was established, and today in 2022. Prior to 1990, local newspapers were dominated by information about agriculture, farming, industry, and rural life. But today, most of the page of local newspapers is non-journalistic information such as news of government agencies, laws and regulations and contract advertising. Also, it can be considered that today's local newspapers cannot deliver information on important topics in many genres, and it is not in the form of information that is attractive to local people.